



**БАТЛАВ:ХАТАНБУЛАГ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА С.ЭРДЭНЭБОЛД**

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

***ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН ТӨВИЙН ХАЯГЖУУЛАЛТЫН АЖЛЫН  
ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ***

**Төслийн нэр:** *Дорноговь аймгийн Хатанбулаг сумын төвийн хаягжуулалтын  
ажил*  
**Төслийн дугаар:** *ХА-2020/01*

Хатанбулаг сум  
2020 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.03.26

*Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газар* нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “*Дорноговь аймгийн Хатанбулаг сумын төвийн хаягжуулалтын*” ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 04-р сарын 07-ний өдрийн 14:00 минутаас** өмнө хаягаар [tender.gov.mn](http://tender.gov.mn) цахим хуудсаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 04 сарын 07-ний өдрийн 14:30** минутанд нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)

Дорноговь аймаг Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газар  
2 давхар 203 тоот утас:95514343

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**

4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.

4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.

4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: <b>Геодези зураг зүйн үйлчилгээ</b> <b>- Геодезийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх;</b>
ТӨӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: <i>Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газар/tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлнэ/</i> Давхар болон өрөөний дугаар: 2 давхар 203 тоот Огноо: 2020 оны 04 сарын 07-ний өдөр Цаг: 14 цаг 00 минут
ТӨӨЗ 2.2	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: <i>Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газар</i> Давхар болон өрөөний дугаар: 2 давхар 203 тоот Огноо: 2020 оны 04 сарын 07-ний өдөр Цаг: 14 цаг 30 минут
ТӨӨЗ 3.1	Долдугаар бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд: <i>1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар/нотариотоор батлуулсан байх/</i> <i>2. Оролцогч компанийн танилцуулга</i> <i>3. Ажлын зураг, тоо хэмжээний дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. /Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсвийн норм үнэлгээгээр тооцно/</i> <i>4. Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны график гарган баталгаажуулж ирүүлнэ.</i> <i>5. Тусгай зөвшөөрлийн баталгаажсан хуулбар / нотариотоор батлуулсан байх/</i> <i>6. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл</i> <i>7. Харилцагч бүх банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</i> <i>8. Татварын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</i> <i>9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</i> <i>10. Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулж, НД7, НД8 маягтын хамт ирүүлэх</i> <i>11. Гэрээг гүйцэтгэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл</i>
	<i>12. Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгааны жагсаалтыг бодит байдлын фото зураг, холбогдох баримт бичгийн хамт ирүүлэх</i> <i>13. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</i> <i>14. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод, гаргацтай байх шаардлагатай.</i> <i>15. ТШӨХ-д шаардсан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд</i>

<i>уг тендерээс татгалзах үндэслэл болно</i>
--

ТӨӨЗ 3.2	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: <i>2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</i> Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байх шаардлагатай эсэх: <i>“шаардлагатай”</i>
ТӨӨЗ 3.2.1	Хийж гүйцэтгэсэн ажлын нийт мөнгөн дүнг жил жилээр харуулсан жагсаалт ирүүлэх шаардлагатай жилийн тоо: <i>2019 он</i>
ТӨӨЗ 3.2.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Дорноговь аймгийн Хатанбулаг сумын төвийн хаягжуулалтын ажил ХА-2020/01 бүхий нэг багц ажил</i>
ТӨӨЗ 3.2.3	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: <i>2019 онд ижил төстэй ажлыг гэрээгээр хийж гүйцэтгэсэн байх.</i>
ТӨӨЗ 3.2.3.1	Борлуулалтын хэмжээ: <i>Сүүлийн 1 жил</i> <i>2019 оны борлуулалтын орлогын хэмжээ нь төсөвт өртгийн 60 хувиас багагүй байх</i>
ТӨӨЗ 3.2.3.2	Ижил төстэй ажлыг нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: <i>Сүүлийн 1 жилд буюу 2019 онд хэрэгжүүлсэн байх</i>
ТӨӨЗ 3.3	Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын судалгааг ирүүлэх
ТӨӨЗ 3.4	Ерөнхий инженер нь гэрээнд заасан ажилтай дүйцэх ажил дээр ажилласан туршлагатай байх жилийн тоо: <i>шаардлагагүй</i> Түүний дотроос гэрээг хариуцаж ажилласан туршлагатай байх жилийн тоо: Голлох инженерийн диплом, цахим үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбаруудыг тус тус ирүүлэх
ТӨӨЗ 3.5	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн <sup>1</sup> нийт дүн: Төсөвт өртөгийн 70%-иас багагүй
ТӨӨЗ 3.6	Түншлэлийн гишүүд дараах нэмэлт шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд: <i>Түншлэгч байгууллагууд гэрээнд гүйцэтгэх ажил үүргийн хуваарийг тодорхой зааж түншлэлийн гэрээнд заасан хуваарийн дагуу ажлыг хийж гүйцэтгэнэ.</i>
ТӨӨЗ 3.7	Тендерт гадаадын этгээд оролцох эрхтэй бол тендерийн хэл нь Монгол хэлнээс гадна дараах хэл дээр байна. Үүнд: <i>Монгол хэл</i> <i>Тендерт оролцогчид дээр тодорхойлсон Монгол хэл дээр бэлтгэж ирүүлэх бөгөөд нэгээс дээш хэл дээр тендерээ бэлтгэж ирүүлэхийг хориглоно. Шалгарсан тендерт оролцогчтой байгуулах гэрээг түүний тендер ирүүлсэн хэл дээр байгуулна.</i>
ТӨӨЗ 4.1	Хувилбарт тендер ирүүлэхийг <i>“зөвшөөрөхгүй”</i>
ТӨӨЗ 4.2	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад <i>“тохируулахгүй тогтмол байна”</i>

<sup>1</sup> Авах боломжтой зээл гэдэгт зээлжих баталгаажсан эрх, харилцагч банкнаас зээл олгох албан мэдэгдэл зэрэг байж болно.

ТООЗ 4.3	Тендерийн валют: <i>Монгол төгрөг байна</i>
ТООЗ 4.4	Тендер нээснээс хойш <b>30</b> хоногийн туршид хүчинтэй байна.
ТООЗ 4.5	Дотоодын давуу эрхийн зөрүү: <b>“тооцно”</b> <i>Дотоодын давуу эрхийн зөрүүг үнэлгээнд тооцох бөгөөд Сангийн яамнаас баталсан “Дотоодын давуу эрхийн зөрүүг үнэлгээнд харгалзах аргачлал”-ыг ашиглан үнэлгээ хийнэ.</i>

### СУМЫН ТӨВИЙН ХАЯГЖУУЛАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Сумын төвийн хаягжуулалт		1048	ш	Хатанбулаг сумын төвд	2020.04.17	2020.07.01	



Дөрөв.

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. Барааны тодорхойлолт: Сумын төвийн хаягжуулалтийн ажлын техникийн тодорхойлолт

*Хатанбулаг сумын төвийн гудамж, хашаа, байшингийн дугаарыг шинэчлэх ажлын тоо хэмжээ*

№	Сум, багийн нэр	Хашааны дугаарын тоо ширхэг	Байшиндугаарын тоо ширхэг	Гудамжны дугаарын тоо ширхэг
1	Хатанбулаг сумын төв	820	137	91
Нийт дүн		1048		



А.1.2-р зураг - Гэр хорооллын гудамжны хаягийн тэмдгийн хэмжээ


#### А.2 Байшин барилгын дугаарын тэмдэг

Байшин барилгын дугаарын хэмжээг А.2.1-р зурагт; Орцны дугаарын хэмжээг А.2.2-р зурагт; Хашааны дугаарын хэмжээг А.2.3-р зурагт; Хаалганы дугаарын хэмжээг А.2.4-р зурагт тус тус үзүүлэв.



Хэмжээ, миллиметр

А.2.1-р зураг - Байшин барилгын дугаарын хэмжээ



А.2.3-р зураг - Хашааны дугаарын хэмжээ

*Дорноговь аймгийн Хатанбулаг сумын төвийн гудамж, хашаа, байшинг хаягжуулахажил:*

*А. Ажил гүйцэтгэх хугацааны график, /Хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи, аргачлал, техникийн тодорхойлолтыг гаргаж ирүүлнэ.*

*Б. Хаягийн тэмдгийг үйлдвэрлэх, хаягийн самбарыг тухайн газарт байрлуулахдаа Монгол Улсын Их хурлаас 2013 оны 02 сарын 07-ний өдөр хэлэлцэн баталсан “Хаягжуулалтын тухай” хууль, Монгол Улсын Засгын газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”, Стандартчилал, хэмжилзүйн үндэсний зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5283:2014ээр хууль эрх зүйн бичиг баримт, норм стандартын дагуу чанартай хийж гүйцэтгэх.*

#### **1. Хаягийн тэмдэг тогтоох ажил:**

-Стандартчилал Хэмжилзүйн газраас 2014 онд батласан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5283:2014 стандартын 6.1.2, 6.1.3-т заасны дагуу хаягийн самбар, тэмдэгийн материал нь байгалийн үзэгдэлд тэсвэрлэхүйц, зэвэрдэггүй хөнгөн цагаан лист, гэрэл ойлгогч зориулалтын өнгөтэй байна.

- Хаяг тэмдгийг 2-3 мм-ийн зузаантай зэврэлтээс хамгаалагдсан түрхлэг бүхий зэвэрдэггүй сайн чанарын төмрөөр хийж, тухайн гудамж, хашаа, байшин зэрэгт байрлуулахдаа хөдөлгөөнгүй бат бэх тогтоож боох болон салхи болон менахик үйлчлэлд нугарахгүй, хугарахгүй байхаар хийж өгнө.

#### **2. Бичлэгт тавих шаардлага:**

-Хаягийн самбарыг үйлдвэрлэхдээ ногоон өнгийн дэвсгэр дээр цагаан өнгийн гэрэл ойлгогчтой будаг эсвэл гэрэл ойлгогчтой хуулгаар хийсэн байх.

-Хаягийн тэмдгийн бичлэгийг кирилл, монгол бичиг, англи хэлээр хослуулан бичнэ.

-Хаягийн тэмдгийн самбар дээрх бичлэг нь нүдэнд харагдахуйц байх бөгөөд шрифтийн хэмжээ нь тэмдэгтийн тооноос хамаарна.

-Бичлэгийг MNS ISO 3098-6:2003, MNS ISO 3098-2:2003, MNS ISO 6275-2:2011 стандартын дагуу хийнэ.

#### **3. Хаягийн тэмдэг болон хаягийн зургийн самбарыг тээвэрлэхэд тавих шаардлага**

-Хаягийн тэмдэг болон хаягийн зургийн самбарын их биен дээр буюу эсвэл тэмдэгт бэхэлсэн тусгай шошго дээр дараах өгөгдөхүүнүүдийг бичсэн байна. Үүнд:

а. Үйлдвэрлэгчийн барааны тэмдэг;

б. Үйлдвэрлэсэн огноо;

-Хаягийг тээвэрлэхдээ хооронд нь зөөлөвч жийрэг хийн хавсарч нүүр будгыг зурахгүй, эвдэрч гэмтээхгүйгээр тээвэрлэнэ.

#### **4. Хаягийн тэмдэг болон хаягийн зургийн самбарыг шалгаж хүлээн авах**

-Хаягийн тэмдэг болон хаягийн зургийн самбарыг туршилт хийн шалгаж, загвар тэмдгийг урьдчилан үйлдвэрлэн ирүүлсний дараагаар стандартын шаардлагыг хангасан тохиолдолд хүлээн авна.

#### **5. Хаягийн тэмдэг болон хаягийн зургийн самбарыг байрлуулах**

-Хаягийн тэмдэг болон хаягийн зургийн самбарыг байрлуулахдаа Монгол Улсын Засгын газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам” болон “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5283:2014 стандартыг баримтална.

Үнэлгээний хорооны дарга  
Нарийн бичгийн дарга  
Гишүүд

Ө.Мөнгөнхөлөг  
Н.Болорцэцэг  
Д.Буянцэцэг  
П.Сайнбуян  
Х.Мөнхжаргал

## Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

### Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

#### Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

#### Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

#### Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

*Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.*

Долоо.ЖИШИГ МАЯГТ  
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.   |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>                                    | <b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b><br>7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b>                         | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.  |
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>                          | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>2</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.  |

<sup>2</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>3</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт

<sup>3</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

**17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**

17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

**18. Гэрээг цуцлах**

18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах

бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

**Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>4</sup>**

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>Дорноговь аймгийн Хатанбулаг сумын төвийн хаягжуулалтын ажил ХА-2020/01 дугаар</i>
ГЕН 2.1	Ажил нь: <i>Дорноговь аймгийн Хатанбулаг сумын төвийн хаягжуулалтын ажлаас бүрдэнэ.</i> Ажлын талбай: <i>Хатанбулаг сумын төв</i>
ГЕН 3.1	Төслийн менежер нь Хатанбулаг сумын Засаг даргын орлогч З.Чимэдцэрэн
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр: 2020.04.17  Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: 2020.07.01
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>[ажлын 5]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа <b>36 сар</b> байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[1 хувь]</i> байна. <sup>5</sup>  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[10 хувь]</i> байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[2020.07.01]</i> -ний дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг <i>[2020.07.01]</i> -ний дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[400,000 төг]</i> байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[1 хувь]</i> -иар тооцно.

<sup>4</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

<sup>5</sup> Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.



## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

### ГҮЙЦЭТГЭГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

ОНХС /ХА-2020/01

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/  
Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

#### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]